

БАГШЛАХ ДАДЛАГА ТҮҮНИЙ ҮР ДҮНД ХИЙСЭН СУДАЛГАА

(Бага боловсролын IV дамжааны оюутнуудын багшлах дадлагын жишээн дээр)

А.Батхшиг, Ч.Бадамсүрэн
МУБИС, Архангайн Багшийн сургууль
A.Batkishig@msue.edu.mn
Ch.Badamsuren@msue.edu.mn

Хураангуй

МУБИС-ийн эрхэм зорилго “Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай багш, боловсролын салбарын мэргэжилтэн бэлтгэх” гэж тодорхойлогдсон бөгөөд үнэт зүйл нь ... “Сурах арга барилтай, хүнлэг, ёс зүйтэй оюутан”, “Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай бүтээлч төгсөгч” юм.

МУБИС нь хөгжлийн стратегидээ ... “Дадлагын чанарыг дээшлүүлэх зорилгоор дадлагын тогтолцоо, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан байна. Багш мэргэжлийг эзэмших үндсэн сургалтуудын нэг бол дадлага юм. Багшлах дадлага нь хичээл төлөвлөх, заах, хичээлийн үр дүнд дүгнэлт хийж засаж сайжруулах чиглэлээр хийгддэг тул оюутан-багшийн хувьд хамгийн чухал дадлагуудын нэг юм.

Учир нь багшлах дадлагаар оюутан-багшийн хичээл төлөвлөх, агуулга болон аргазүйн боловсруулалт хийх, хэрэглэгдэхүүн боловсруулж хийх, үнэлгээний даалгавар боловсруулах, сурагчдыг үнэлэх дүгнэх, заах, засаж сайжруулах үйлүүдийг биечлэн хийж гүйцэтгэдэг. Иймд багшлах дадлага чанартай, үр дүнтэй болж байж сайн багш бэлтгэгдэн гарна.

Энэхүү өгүүлэл нь оюутан-багшийн хувьд багшлах дадлага хийхэд тулгамдсан асуудлыг илрүүлэн, засаж сайжруулах арга замыг тодорхойлох зорилготой.

Түлхүүр үг: Оюутан-багш, хичээлийн төлөвлөлт, арга зүй, үр дүн

Оршил: Багш мэргэжилтэй хүн бүхэн сурган хүмүүжүүлэх арга ухаан, сурагчдыг оношлох арга зүй, мэдээлэл холбооны технологи, харилцаа хандлага, хувь хүний соёл зэрэг олон ур чадварыг эзэмшсэн байх шаардлагатай. Багшлах дадлагаар оюутнууд онолын мэдлэгээ сургуулийн практикт туршиж, үр дүнд нь багшлах эв дүй, ур чадварт суралцдаг. 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн 6 дадлага: Танилцах дадлага 1 кр, Судлах дадлага-I, 1 кр, Судлах дадлага-II, 2 кр, Дагалдан суралцах дадлага 3 кр, Туршин заах дадлага 3 кр, Багшлах дадлага 4 кр нийт 14 кр байсан бол 2018-2019 оны хичээлийн жилээс 4 дадлага 11 кр биелүүлэх: Танилцах дадлага 1 кр, Судлах дадлага 2 кр, Туршин заах дадлага 3 кр, Багшлах дадлага, 5 кр хичээлийн жилээс 3 дадлага нийт 9 кр биелүүлэхээр үүнд: Танилцах дадлага, 1 кр, Судлах дадлага 2 кр, Багшлах дадлага, 6 кр болж өөрчлөгдсөн. Өөрөөр хэлбэл жил ирэх бүрт заавал биелүүлэх дадлагын тоо болон заавал биелүүлэх кр буурсан байна.

Судалгааны арга зүй: Асуулгын арга, фокус бүлгийн ярилцлагын арга, ажиглалтын арга, математик тооцооллын аргуудыг ашигласан.

Зорилго: “Багшлах дадлага”-ын хэрэгжилтэд судалгаа хийх, тулгамдаж буй асуудлыг тодруулах

Зорилт:

1. Оюутан-багшаас ажиглалтын болон асуулгын аргаар судалгаа авч, үр дүнд дүгнэлт хийх

2. ЕБС-ийн дадлага удирдсан багш нараас фокус бүлгийн аргаар судалгаа авч, үр дүнд анализ хийх, цаашид анхаарах зүйлийг дараагийн дадлагад тусгах

Үндсэн хэсэг

Багшлах дадлагын зорилго нь Оюутан-багш бие дааж хичээл заах, анги удирдах, сурагчийг үнэлэх, тодорхой чиглэлээр судалгаа хийхэд суралцаж, сургалтын болон сургалтыг дэмжих үйл ажиллагааг төлөвлөх чадвар эзэмшинэ.

Тухайн мэргэжлийн хичээлийг хамтран төлөвлөх, зохион байгуулах, хичээлийн ажиглалт, тэмдэглэл хөтлөх, хэлэлцэх, багшийн арга зүйгээс суралцах, сайжруулах аргад суралцсан байна. Багш мэргэжлийн дадлагын дэвтэр II –т (МУБИС. (2019) зааснаар: Бие даан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, Тодорхой судлагдахууны агуулга, багшлах арга зүйн чиглэлээр судалгаа хийх, Хичээл заах арга зүйг төлөвлөх, тодорхой сэдвийн хүрээнд сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, хэрэгжүүлэх, судлах, Судалгаат хичээлийг мэргэжлийн багштай хамтран төлөвлөх, ажиглах, хэлэлцүүлэгт оролцох, Багшлах ур чадвараа хөгжүүлэх, сургалтын тодорхой арга зүй эзэмших, Сургалтыг дэмжих үйл ажиллагааг төлөвлөх, бие даан зохион байгуулах, Хүүхдийг судлах, суралцахуйн бэрхшээлийг илрүүлж, зөвлөгөө өгөх зэргийг тусгасан байна.

Судалгааны үр дүн I:

I. Бага боловсролын IV курсийн 40 оюутан-багшаас Хичээлийн бэлтгэлд хандах хандлага ба оюутан-багшид тулгамдсан асуудлыг илрүүлэх, Сургалтын хөтөлбөр боловсруулахад тулгамдаж байсан зүйлийг 1-5 оноогоор эрэмблэх, сургалтын хэрэглэгдэхүүний боловсруулалт, оюутан-багш

өөрөө хийж байгаа эсэхийг тодруулах багшлах дадлагаар эзэмшсэн чадвар, дадлагыг хэрхэн сайжруулах талаар асуумж судалгаа асуулгын аргаар судалгаа авч, үр дүнд дүгнэлт хийсэн.


Зураг 1.



Судалгаанд хамрагдсан оюутнуудын 58% 1-2 хоногийн өмнөөс хичээлийн бэлтгэлээ хийдэг, үүнээс 37,5% “хангалттай хугацаа байж чадаагүй”, 24% 3-4 хоногийн өмнөөс заах хичээлээ төлөвлөн бэлтгэдэг, үүнээс “хугацааны хувьд боломжийн байсан” гэж 94% нь хариулсан байна.

Асуулга 2: Дадлагын хугацаанд ямар асуудал хамгийн их тулгамдаж байсан бэ?

Хүснэгт 1



Хичээлийн бэлтгэлийг боловсруулахад 58% нь 1-2 хоног зарцуулдаг. Энэ нь давчуу хугацаа болох нь (37,5%) харагдаж байна. Иймд дадлагын удирдамжид хичээл заах цагийн тоог эргэж харах, нөгөө талаас оюутнуудын хувийн зохион байгуулалтыг сайжруулахад анхаарах хэрэгтэй байна. Санхүүгийн бэрхшээл хүндрэлтэй 45%, Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэхэд хүндрэлтэй 33% нь хариулсан байна.

Эдгээр бэрхшээлийг заах аргын хичээлүүдийн бие даалтын ажлын хүрээнд хэрэглэгдэхүүн бэлтгүүлж, сан бүрдүүлэх чиглэлээр шийдвэрлэх боломжтой гэж үзлээ.

“Бусад” гэсэн хариултанд Мэргэжлийн заах аргын хичээлүүд ороогүй, Заах аргын хичээлүүд ороогүй, Заах аргын багш нараас цахимаар зөвлөгөө авах ба Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ааш араншинд тааруулан харилцахад хүндрэлтэй байсан. АУБ хичээл заах сэдвийг 1 өдрийн өмнө өгч байсан, хичээлийн бус цагаар юм хийлгэх, заавар зөвлөгөө өгдөггүй зэрэг асуудлууд тулгамдаж байсан гэж хариулжээ.

Иймд дадлагын удирдамжинд ЕБС-ийн дадлага удирдаж байгаа эрх, үүргийг тодорхой оруулах, мөн онцгой нөхцөлд орсон цахим хичээлүүд ялангуяа заах аргын цахим хичээлүүдийн чанар, үр дүнг эргэн харах шаардлагатай байна.

“Ээлжит хичээл төлөвлөхөд хүндрэлтэй” гэж 6 оюутан буюу 15% нь хариулсан нь харьцангуй бага буюу оюутан-багш нар хөтөлбөр боловсруулах арга зүйг эзэмшсэн гэж харахаар байна. Гэтэл дадлага удирдсан ЕБС-ийн болон МУБИС-ийн заах аргын багш нарын ажиглалтаар хамгийн тулгамдсан асуудал нь энэ байлаа.

Иймээс сургалтын хөтөлбөр боловсруулахад яг ямар асуудал тулгарч буйг илрүүлэх зорилгоор дараах асуулгыг 27 оюутан-багшаас түүврийн аргаар авсан болно.

Асуулга 3. Сургалтын хөтөлбөр боловсруулахад тулгамдаж байсан зүйлийг 1-5 оноогоор эрэмбэлнэ үү? (Хамгийн их тулгамдсан асуудал нь 5 оноо байна.)


Хүснэгт 2.

№	Бүтэц	1 оноо	2 оноо	3 оноо	4 оноо	5 оноо	Нийт оноо
1	Зорилго, зорилт тодорхойлох	9	9	7	2	0	56
2	Агуулга боловсруулах	0	3	6	8	10	106
3	Арга зүй боловсруулах	3	5	7	8	4	86
4	Хэрэглэгдэхүүн боловсруулах	6	5	7	5	4	75
5	Үнэлэх, дүгнэх	11	4	2	6	4	69

Оюутнуудын хувьд хичээлийн хөтөлбөр боловсруулахад хамгийн тулгамдсан асуудал нь агуулгын болон арга зүйн боловсруулалт байна. Иймд оюутны онолын мэдлэгийг сайжруулах, шинжлэх ухааны агуулгыг хичээлийн агуулга болгон хялбаршуулах, тухайн хичээлд тохирох сургалтын аргыг биеэр мэдрэх аргаар эзэмшүүлэхэд анхаарахад шаардлагатай байна. Сургалтын аргыг заах арга зүйн хичээл тус бүрээр үздэг хэдий боловч ихэнх оюутан-багш тухайн хичээлд тохирсон аргыг хэрэглэж мэдэхгүй байна.

Асуулга 4. Дадлагын хугацаанд ихэвчлэн ямар сургалтын хэрэглэгдэхүүн хэрэглэсэн бэ? (Сургалтын хэрэглэгдэхүүний боловсруулалт, оюутан-багш өөрөө хийж байгаа эсэхийг тодруулах зорилгоор)

Зураг 2.



Ихэнх оюутнууд хэвлэмэл үзүүлэнг шууд авч хэрэглэсэн нь үзүүлэн бэлтгэх, боловсруулах чадвар дутмаг нөгөө талаас хэрэглэгдэхүүн бэлтгэх цаг хугацаа давчуу байсантай холбоотой. Оюутнууд хэвлэмэл үзүүлэн ихэвчлэн хэрэглэсэн нь санхүүгийн бэрхшээлтэй тулгарахад хүргэсэн байх магадлалтай.

Асуулга 5. Багшлах дадлагаар ямар чадварыг эзэмшсэн бэ?

Зураг 3.



Дадлагын явцад ихэнх оюутнууд сурагчидтай зөв харилцах, сургалтын арга хэрэглэх, хүүхэд бүрт хүрч ажиллах, сурагчдын анхаарлыг төвлөрүүлж анги зохион байгуулахад суралцсан байна.

Асуулга 6. Багшлах дадлагыг сайжруулахын тулд яах хэрэгтэй вэ? /Санал хүсэлтээ бичнэ үү/ нээлттэй асуултанд ЕБС-ийн дадлага удирдсан багш нарт дадлага удирдах удирдамж, зөвлөмж хүргүүлэх, Оюутан- багш хичээлийн бэлтгэлд хариуцлагатай хандах, хэлэлцүүлгийг хийх, Дадлагын хугацааг уртасгах, Заах аргын хичээлүүдийн үр дүнг сайжруулах, Хэрэглэгдэхүүн бэлтгэхэд МУБИС-ийн заах аргын багш нар анхаарах, ЕБС-ийн дадлага удирдсан багш нарын ажилласан жил, туршлагыг харгалзах гэсэн саналуудыг дэвшүүлсэн байна.

Судалгааны үр дүн II. Дадлага удирдсан ЕБС-ийн багш нараас фокус бүлгийн аргаар судалгаа авч, үр дүнд анализ хийсэн. Судалгаанд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын I-III сургуулийн бага ангийн 18 багш хамрагдав.

Зураг 4



Асуулга 1: Оюутан багштай хамтарч ажиллахад танд бэрхшээл тулгарч байсан уу?

Оюутны онолын мэдлэг, бүтээлч үйл ажиллагаа, багаар ажиллах чадваруудыг сул гэж дүгнэсэн байна.

Асуулга 2: Оюутан-багш хичээлийн бэлтгэл хийх явцад болон хичээлийн дараа та ямар зөвлөгөөг өгч байсан бэ?

Хүснэгт 2.

Зөвлөгөө	Багшийн тоо /давхардсан/	Эзлэх хувь
Хичээлийг заах агуулгын болон арга зүйн төлөвлөлт	10	55.5%
Хичээлийн хэрэглэгдэхүүний чанар, шаардлага	8	44.4%
Хичээл зохион байгуулалт	6	33.3%
Багшийн эв дүй /дууны өнгө, өөртөө итгэх /	5	27.7%
Хичээлийн үе шат, цаг хуваарилалт /сэдэлжүүлэлт, үнэлгээ дүгнэлт/	3	16.6%
Хичээлийн технологи, бүтэц	2	11.1%
Зөв бичих дүрмийн алдаагүй бичих	2	11.1%
Онолын ойлголт	2	11.1%
Сургалтын идэвхтэй арга ашиглах	2	11.1%

Дээрх судалгаанаас харахад хичээлийн төлөвлөлт боловсруулах (99.9%) тэр тусмаа агуулгын болон арга зүйн боловсруулалт хийх тал дээр 56% нь зөвлөгөө өгч байсан нь оюутан-багшийн тулгамдсан асуудал нь хичээлийн хөтөлбөр боловсруулах болохыг харуулж байна.

Оюутан-багшийн дадлагын үр өгөөжийг дээшлүүлэх, багш бэлтгэдэг сургуулийн сургалтын чанарын талаар ЕБС-ийн дадлага удирдсан багш нартай фокус бүлгийн ярилцлага хийхэд: Хичээлийн хөтөлбөрийг боловсруулж сургахад онцгойлон анхаарах (ялангуяа сургалтын шинэлэг аргуудыг хэрэглэж сургах, хэрэглэгдэхүүний боловсруулалт, үр өгөөжид анхаарах), Онолын мэдлэгийг дээшлүүлэх, Багш мэргэжлийн онцлогийг мэдэх, ойлгох /сэтгэл дутах, хойрго хандах, хэнэггүй байдал/, Оюутныг дадлагын явцад хариуцлагатай байлгах, хувийн зохион байгуулалтыг нь сайжруулах, Ёс зүйтэй байлгах, Дадлагын мөнгийг цаг тухайд нь олгох гэсэн саналуудыг дэвшүүлжээ.

Дүгнэлт

1. Заах аргын хичээлүүдийн ялангуяа цахим хичээлүүдийн чанар, үр дүнг сайжруулах хэрэгтэй.

2. Оюутан-багшийн дадлагын хичээлээс өмнө сургалтын хөтөлбөр боловсруулж сургах, сургалтын аргаа өөрийн болгох, хэрэглэгдэхүүн боловсруулах зэрэг үр чадваруудыг эзэмшүүлэхийн тулд заах аргын хичээлүүдийн агуулгыг интеграцчлах замаар семинарын цагийн тоог нэмэгдүүлэх ба хэрэглэгдэхүүний сантай болгох боломжтой.

3. Оюутны бүтээлч үйл ажиллагаа, багаар ажиллах чадвар, хувийн зохион байгуулалт, хариуцлагатай байх чадваруудыг эзэмшүүлэх шаардлагатай.

4. ЕБС-ийн багш нарын ажлын ачаалалыг тооцож, дадлагын удирдамжид багшийн гүйцэтгэх эрх, үүргийг тодорхой тусгах хэрэгтэй байна.

THE STUDY AND RESULTS ON TEACHING PRACTICE

Abstract

One of the basic trainings to become a teacher is teaching practice. Teaching is also one of the essential practices because it is organized through activities as planning lessons, teaching, making analysis on lesson results, and improving disadvantages.

During teaching practice student-teachers implement the following activities by themselves: plan lessons / elaborating contents and methods, creating and developing learning resources, elaborating assessment assignments, assessing learners/, teach lessons, fix mistakes and improve lessons. If teaching practice is qualitative, there will be good teachers in the future. This article is aimed to identify the problems facing with student-teachers and define the ways of deciding the problems and improving it.

Зохиогчийн тухай:

1. А.Батхишиг – МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн БУ-ны тэнхимийн эрхлэгч. Математик арга зүйн хичээлүүд заадаг. Хэлэлцүүлсэн илтгэл -10, хэвлүүлсэн өгүүлэл-13, гарын авлага-2. Судалгааны чиглэл- бага ангид математик заах арга зүй
2. Ч.Бадамсүрэн-МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн Бага боловсролын тэнхимийн багш. Бага боловсролын арга зүйн чиглэлээр ажиллаж байна. Хэвлүүлсэн өгүүлэл-14, гарын авлага-4, ном-1, илтгэл 4 хэвлүүлсэн.

Ном зүй

1. МУБИС. (2016). Багш мэргэжлийн дадлагын дэвтэр I, Улаанбаатар.
2. МУБИС. (2016). Багш мэргэжлийн дадлагын дэвтэр II, Улаанбаатар.
3. МУБИС, (2017). Бага боловсролын асуудал, шийдэл, ЭШБ, Улаанбаатар.
4. МУБИС, (2014-2024). Хөгжлийн бодлого. Улаанбаатар.